

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ

2021 оны 09 сарын 21 өдөр

- Хүнс, Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2021 оны А/63 дугаар тушаалаар тус газрын бүтэц орон тоог нийт 3 алба 19 орон тоотой байхаар баталсан.
- ХХААГазар нь одоогийн бүтцээр нийт 3 албанд 18 орон тоотой ажиллаж байна.
- Удирдах-1, гүйцэтгэх-10 ,туслах-6
- Мал үржлийн албаны сул орон тооны захиалгыг төрийн албаны салбар зөвлөлийн аймгийн салбар зөвлөлд газрын даргын 2021 оны 01/23 тоот албан бичгээр хүргэн ажилласан.

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН АЛБАДЫН ЧИГ ҮҮРЭГ:

1. МАЛ ҮРЖЛИЙН АЛБА

Мал аж ахуйн чиглэлээр гарсан төр засгийн бодлого хууль тогтоомж, хөтөлбөр, дүрэм журмыг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, малын удмын санг хамгаалан, сайжруулах, нийт мал сүргийг мэдээллийн санд бүртгэлжүүлэх, бэлчээрийг ашиглах, хамгаалах, МАА-г эрчимжүүлэх, энэ талаар аймгийн төлөвлөгөөнд тавигдсан зорилтуудыг хэрэгжүүлж үржлийн нэгж, мал бүхий иргэд, малчид, хуулийн этгээдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах. /4 орон тоотой/

2. ҮЙЛДВЭР ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА

Хүнс, газар тариалан, хөнгөн болон жижиг дунд үйлдвэр, худалдаа үйлчилгээ хоршоо, бирж, ахуйн үйлчилгээний чиглэлээр гарсан хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангах, сумдын Хөдөө аж ахуйн тасаг болон холбогдох албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах. /3 орон тоотой/

3. ЗАХИРГАА АЖ АХУЙН АЛБА

ХХААГ-ын хүний нөөцийн болоод захиргааны үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах /11орон тоотой/

Засгийн Газрын 2020 оны 216-р тогтоолоор батлагдсан журам болон Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалаар батлагдсан байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу төлөвлөгөөг боловсруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 14 тоот тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 13 тоот тогтоолоор батлагдсан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, ХХААХҮ-ийн Сайдын 2021 оны А/28 тушаалаар батлагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө зэргийг үндэслэн дүн шинжилгээ хийж, боловсруулан үндсэн 8 чиг үүрэг, ерөнхий 3 чиг үүргийн хүрээнд 10 зорилтыг 45 арга хэмжээгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2021 оны 04 сарын 30 өдөр аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны тушаалаар байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан, шаардлагыг хангасан албан хаагчид ажилладаг.

Байгууллагын дотоод журмыг 2004 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд, 2005, 2006, 2007, 2008, 2014, 2020 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан 2021 онд байгууллагын албан хаагчдын “Нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг шинээр боловсруулан тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөний хамт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХХААГ-ын даргын 2020 оны А/06 тоот тушаалаар байгууллагын Ёс зүйн зөвлөлийг байгуулсан. Зөвлөлийн хийх ажлын жилийн төлөвлөгөө гарган, байгууллагын албан хаагчдын дунд “Итгэл даах-Төрийн алба” төлөвшүүлэх нь уриалгыг гарган хэрэгжүүлэн ажиллаа.

Нийт төрийн албан хаагч нартай Ёс зүйн дүрэм”-ийг сахих талаар хариуцлагын гэрээ байгуулан ажилладаг.

Төрийн албаны хүний нөөцийн цахим системд төрийн албан хаагч нарын мэдээллийг оруулж мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг бүрэн зохион байгуулсан.

Төрийн албан хаагч нарын хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүрдүүлэн жилийн эхэнд болон эцэст шинээр ажилд орсон эсвэл баяжуулалт хийх шаардлага гарсан тухай бүр бүртгэл баяжуулалтыг хийн ажиллаж байна.

Тус байгууллагад 2021 онд Төрийн захиргааны албан тушаалын 2 сул орон тоог Төрийн албаны салбар зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн холбогдох хугацаанд мэдээлсэн. МҮАлбаны /Бэлчээр усан хангамж хариуцсан мэргэжилтэн/-ий ажлын байранд Төрийн албаны зөвлөлөөс COVID-19 цар тахалтай холбогдуулан гаргасан зөвлөмжийн дагуу хөдөлмөрийн түр гэрээгээр 1 иргэнийг ажиллуулж байна.

Сургалт,сурталчилгаа,тайлан мэдээ, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Л.Нарантуяа, үйлчлэг Ё.Дааримаа нар нь хүүхэд асрах чөлөөний амралттай байгаа учир Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалт, Засгийн Газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн нөөцөд байсан иргэнийг түр хугацаагаар, хөдөлмөрийн гэрээгээр түр хугацаагаар ажиллуулж байна.

Нийт 18 албан хаагчаас удирдах 1, гүйцэтгэх 11, туслах 6 албан хаагч, эмэгтэй 8, эрэгтэй 10 албан хаагч ажиллаж байна. Төрийн албанд ажилласан жилээр авч үзэхэд 0-5 хүртэл жил ажилласан 5,6-10 жилд 6, 11-15 жил ажилласан 4, 16-20 жилд-2, 26-30 жил ажилласан 1 ба нийт албан хаагчдын 78,2 хувь нь 5 дээш ажилласан туршлагатай албан хаагчид ажилладаг.

ХХААХҮЯамнаас хэрэгжүүлж буй гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө,нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөө хэрэгжилт, ажлын гүйцэтгэл үр дүнг тооцож амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллага, албадууд хагас бүтэн жилээр,төрийн албан хаагчид сар бүр цахим мэдээллийн санд ажлаа тайлагнадаг.

2020 оны жилийн эцэст албан хаагч нарын ажлыг дүгнэн, сайн ажилласан 5 албан хаагчид зэрэг дэв олгуулахаар Төрийн албаны салбар зөвлөлд санал хүргэн, 2021 оны 15 дугаар тогтоолын дагуу 5 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгож, төрийн захиргааны 5, төрийн үйлчилгээний 1 албан хаагчийн цалингийн шатлалыг ахиулсан.

Төрийн үйлчилгээний албан хаагч нарын ажлыг улирлаар дүгнэж ур чадварын нэмэгдлийг сар бүр 10-25 хувиар олгож байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбогдолтой А/тушаал-18, боловсон хүчний чиглэлээр Б/тушаал -9 нийт 27 тушаал холбогдох хууль, эрхзүйн актыг үндэслэн гарсан. Аймгийн ЗДТГазрын хууль эрх зүйн хэлтсээр 2021 оны эхний хагас жилд гарсан эрхзүйн актуудыг хянуулж заавар зөвлөгөө авч ажилласан.

Аймгийн хэмжээний Хүнс хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчний хүрэлцээ хангамжийг тооцоход 69,1 хувьтай байна. Хүнс хөдөө аж ахуйн газарт тогтвор суурьшилтай ажилласан төрийн жинхэнэ албан хаагч-10, сумдын хөдөө аж ахуйн тасагт 12 нийт 22 албан хаагч тогтвор суурьшилтай 3 аас дээш жил ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх удирдамж гаргаж, зорилт дэвшүүлэн “Хамтдаа сурч-Хамтдаа хөгжье” facebook групп нээж төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт байгууллагын албан хаагчдыг 100 хувь хамруулсан.

Байгууллагын хашаанд 570 м/2 хүлэмжид өргөст хэмх, улаан лооль, чинжүү зэргийг тариалж байна. Мөн 0,3 га талбайд төмс хүнсний ногоо тариалж, байгууллагын хашаанд улиас, бургас, хайлаас, шар хуайс, чацаргана, царгас зэрэг модлог болон бутлаг ургамлууд шинээр тариалж, ургуулж байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН БҮТЭЦ

“ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН 2021
ОНЫ А-63 ДУГААР ТУШААЛ”



